


ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



*ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТТАЙ БАЙНА.*

Даланзадгад хот
2017 он

Агуулга

Тайлан бэлтгэсэн: Дарга, Тэргүүлэх аудитор П.Алтанзаяа Аудитын менежер Д.Алдармөнх Ахлах аудитор Т.Хонгорзул Аудитор Д.Сүрэнжаргал Н.Отгонбаяр Ш.Отгонбаяр Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539 дугаарын утсаар харилцана уу ХАЯГ: Нутгийн удирдлагын ордон 303 тоот Даланзадгад сум Өмнөговь аймаг	Товчилсон үгийн жагсаалт Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт Бүлэг А А.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдсан байна. А.2 Байгууллагууд шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж мэдээлсэн байна. Бүлэг Б Б.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг 95,9 хувьтай мэдээлсэн байна. Б.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг 99,4 хувьтай мэдээлсэн байна. Б.3 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 6 дугаар зүйлийн 6.5- д заасан мэдээллийг мэдээллэх гэсэн заалт нь Сангийн яамтай холбоотой бөгөөд орон нутагт хамааралгүй болно. Б.4 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлсэн байна. Б.5 Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.9- дэх хэсэгт заасан мэдээллийг журмыг дагуу мэдээллэж байна. Бүлэг В В.1 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг зарим сумын ИТХ хэрэгжүүлээгүй байна. В.2 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. В.3 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д заасны дагуу ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг тусгасан байна.
--	--

	В.4 Хуулийн 9 дүгээр зүйлд заасан иргэний хяналт хангалтгүй байна. Бүлэг Г Г.1 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. Г.2 Өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна. Дүгнэлт Албан шаардлага Хавсралтууд Судалгаа №1 Судалгаа №2 Судалгаа №3 Судалгаа №4
--	--



Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл

АУДИТЫГ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 02 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, бүрэн хамрагдсан эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүхэн мэдээлж байгаа эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтнуудыг хамруулав.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, иргэд, хэрэглэгчдээс судалгаа авах зэрэг аудитын арга зүйг ашиглаж аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТ ХИЙХЭД АШИГЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллий ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2016 оны “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

АУДИТ ХИЙСЭН БАГ, ХУГАЦАА

Аудитыг Тэргүүлэх аудитор П.Алтанзаяа, менежер Д.Алдармөнх нар хянан удирдаж, ахлах аудитор Т.Хонгорзул, аудитор Д.Сүрэнжаргал, Н.Отгонбаяр, Ш.Отгонбаяр нар 2017 оны 10 дугаар сарын 16-ний өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 20 өдрийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Бүлэг А

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан байна.

А.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдсан байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд нэгдсэн цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹-д заасны дагуу улсын төсвийн 39 байгууллага, түүний харъяа 3 сан, орон нутгийн төсвийн 138 байгууллага, ОНӨААТ 35 үйлдвэрийн газар нийт 215 байгууллага Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3²-д заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа “Таван толгой” ХКомпани, “Гүний ус” ХХКомпани шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршиж бүрэн хамрагдсан байна.

Улс, орон нутгийн төсвийн 215, төрийн өмчит үйлдвэрийн газар 6, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа 2 байгууллага нийт 223 байгууллага Өмнөговь аймгийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршиж, хамрагдалт 100 хувь байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршсан байдал

Төсвийн ерөнхийлөн захирагчид	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Цахим хуудас нээсэн
Яам	ТШЗ	40	40
	Сан	3	3
Орон нутгийн байгууллага	ТШЗ	105	105
	ТЕЗ	1	1
	ТТЗ	15	15
	ОНӨААТҮГ	35	35
	ААНБ	2	2
	Сан	16	16
	ТӨХК, ТӨҮГ	6	6
	Нийт дүн	223	223

¹ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

² Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани

А.2 Байгууллагууд шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж мэдээлсэн байна.

Байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээлэлийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг баримтлан мэдээлж байна.

Бүлэг Б

Хуулийн хэрэгжилт өмнөх оноос
8,75 хувиар өссөн байна.**Б.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг 95,9 хувьтай мэдээлсэн байна.**

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 15 сумдын улс, орон нутгийн байгууллагуудыг хамруулан объект дээр ажиллан 2016 оны 10 дугаар сараас 12 дугаар сар, 2017 оны 1 дүгээр сараас 9 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл байдлаар харилцахын хуулга, НББ-ийн анхан шатны баримт, захирамж, тушаал шийдвэр болон холбогдох бусад мэдээ тайлантай тулган шалгалаа.

Улс, орон нутгийн төсвийн 215, төрийн өмчит үйлдвэрийн 6 газар аудитад хамрагдсанаас хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээлвэл зохих 3605 мэдээллээс 3259 буюу 90.4 хувийг хугацаандаа мэдээлсэн, 294 буюу 9.6 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн, 52 мэдээлэл буюу 1.4 хувийг мэдээлээгүй байна.

*Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх мэдээллийг
байршуулсан байдал*

Хүснэгт № 2

Хуулийн заалт	Заалтууд	Мэдээлвэл зохих тоо	Мэдээлсэн		Нийт мэдээлсэн	Мэдээлээгүй	Мэдээлсэн хувь
			Хугацаандаа	Хугацаа хоцроосон /залруулсан/			
6.1.1	Тухайн жилийн төсөв	212	192	15	207	5	97.6
	ОНХС-ийн төлөвлөлт	16	14	2	16	0	100
	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	21	17	2	19	2	90.4
6.1.2	Төсвийн гүйцэтгэлийн мэдээ	2557	2357	196	2553	4	99.8
6.1.3	Дараа жилийн төсвийн төсөл	180	122	46	168	12	93.3
6.1.4	Хагас жилийн эцсийн санхүүгийн тайлан	212	200	5	205	7	96.6
	Жилийн эцсийн санхүүгийн тайлан	211	164	26	190	21	90.4
6.1.6	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	196	193	2	195	1	99.9
Нийт дүн		3605	3259	294	353	52	95.9

Хүснэгтээс харахад хуулийн 6.1.1-д заасан тухайн жилийн батлагдсан төсвийг 96 хувь, 6.1.2-т заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 99.8 хувьтай тус тус мэдээлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх мэдээллийн хуулийн хэрэгжилт 95,9 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Хуулийн 6.1 дэх мэдээллийг байршуулсан хувийг өмнөх оны аудитын дүнтэй харьцуулахад бүх заалтууд дээр өссөн, мэдээлсэн дундаж хувь 2,4 хувиар өссөн байна.

График-1



Б.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг 99,4 хувьтай мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан долоо хоногийн дотор мэдээлвэл зохих нийт 7588 мэдээллээс 7370 буюу 97.1 хувь хугацаандаа, 151 буюу 3.9 хувийг аудитын явцад залруулан хугацаа хоцроож мэдээлсэн, 67 буюу 0.8 хувийг мэдээлээгүй байна.

Мэдээлэл байршуулсан байдлыг харуулбал:

Хүснэгт 2

Хуулийн заалт	Заалтууд	Мэдээлэх тоо	Мэдээлэл		Нийт мэдээлсэн	Мэдээлээгүй	Мэдээлсэн хувь
			Хугацаандаа	Хугацаа хоцорсон			
6.4.1	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	212	212	0	212	0	100
6.4.4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт	172	172	0	172	0	100
6.4.5	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	4355	4257	64	4321	34	99.2
6.4.6	Худалдан авах ажиллагаанд хийсэн	177	177		176	1	99.4


Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

	аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн			0			
6.4.7	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	194	192	0	192	2	98.9
6.4.8	Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	2478	2361	87	2448	30	98.7
Нийт дүн		7588	7370	151	7521	67	99.4

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх мэдээллийн хуулийн хэрэгжилт 99,4 хувьтай байна.

Хуулийн 6.4 дэх мэдээллийг байршуулсан хувийг өмнөх оны аудитын дүнтэй харьцуулахад бүх заалтууд дээр өссөн байна. Хуулийн 6.4.8 дэх мэдээллийг мэдээлсэн хувь 31.2 хувиар, 6.4 дэх мэдээллийг мэдээлсэн дундаж хувь 15,4 хувиар өссөн байна.

График-2



Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаандаа үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтлан ажиллах зөвлөмжийг Аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Б.3 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 6 дугаар зүйлийн 6.5-д заасан мэдээллийг мэдээллэх гэсэн заалт нь Сангийн яамтай холбоотой бөгөөд орон нутагт хамааралгүй болно.

Б.4 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлсэн байна.

Орон нутгийн өмчийн оролцоотой Таван толгой ХК, Гүний ус ХХКомпаниудад хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээлэл гараагүй байна.

Б.5 Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.9-дэх хэсэгт заасан мэдээллийг журмыг дагуу мэдээллэж байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.9³ заасан улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа, аж ахуй нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийг ЗГ-ын 2014 оны 384-р тогтоолоор батлагдсан журмын дагуу мэдээлэх үүргийг төсвийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас, мэдээллийн самбараар хэрэгжүүлж байна.

3 Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвтнэгдсэн цахим хуудсанд байршуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.

Бүлэг В**Шилэн дансны үйл ажиллагаанд
тавих иргэдийн хяналт
хангалтгүй байна.****В.1 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг зарим сумын ИТХ хэрэгжүүлээгүй байна.**

Тус хуулийн 3.1-д заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг сумдын ИТХ ажлын хэсэг гаргаж хяналт шалгалтыг хэрэгжүүлэн хийгдсэн хяналт шалгалтын тайланг хэлэлцэн цаашид анхаарах асуудал зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилласан байна.

Гэвч аймгийн ИТХ, Мандал-Овоо, Хүрмэн сумын ИТХ хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд дээрх зөрчил гаргасан аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт хууль хэрэгжүүлж шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах тухай албан шаардлагыг хүргүүллээ.

В.2 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2⁴ заасны дагуу 2017 оны 1, 2, 3 дугаар улиралд Санхүүгийн хяналт, аудитын алба тус хуулийн хэрэгжилтэд хяналт хийж ажилласан байна

Шалгалтаар 125 төсвийн байгууллага, 37 ОНӨААТҮГ, 16 ОНХСан нийт 178 байгууллага хамрагдаж, шилэн дансны цахим хуудсанд 1876 мэдээлэл мэдээлэхээс 1835 мэдээлж, мэдээллийг 97,8 хувьтай байршуулсан байна. Дээрх байгууллагууд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч мэдээллийг хуулийн хугацаанд байршуулаагүй, хугацаа хоцроох, мэдээллээ оруулсан гэсэн тэмдэглэгээ байгаа боловч ороод үзэхэд мэдээллээ оруулаагүй хоосон байгаа зэрэг зөрчлийг гаргасан байна. Энэ нь мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг хэрэгжүүлэхгүй байгааг харуулж байна.

Эхний хагас жилд шилэн дансны мэдээллээ 80-аас доош хувиар мэдээлсэн 13 байгууллагын дарга, нягтлан бодогч нарт албан шаардлага хүргүүлэн биелэлтийн тооцож ажилласан байна.

МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын 8.25 дах заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

⁴ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

⁵ санхүүгийн хяналт, аудитын алба улирлын нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ

В.3 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д заасны дагуу ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг тусгасан байна.

Орон нутгийн төсвийн байгууллагын нягтлан бодогчдын ажлыг 2016 оны жилийн эцэст дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлсэн байдал, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан байдал зэргийг үзүүлэлт болгон оруулж дүгнэсэн байна.

В.4 Хуулийн 9 дүгээр зүйлд заасан иргэний хяналт хангалтгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу цахим санд тавигдсан мэдээллийн зөрчил дутагдал, хэрэгжилтийн явцын талаар байгууллага, албан тушаалтанд тавьсан шаардлагыг хүлээн аваагүй талаар гомдол мэдээлэл иргэдийн зүгээс ирээгүй байна.

Энэ нь нэг талаар иргэд шилэн дансны мэдээллийг ашиглахгүй байгаатай холбоотой байна. Цаашид иргэдийн оролцоо, хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх, шилэн дансны цахим хуудсаар авч болох мэдээллийн ач холбогдолыг сурталчилан хандалтыг тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Бүлэг Г

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Г.1 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх аудитаар илэрсэн 6,174.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах тухай албан шаардлагыг Аймгийн Засаг даргад хүргүүлсэн. Албан шаардлагын дагуу гарсан зөрчлийн жагсаалтыг сум, байгууллагуудад 2017 оны 01 сарын 11-ний 7-51 албан бичгээр хүргүүлж, энэ хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг ирүүлэх үүрэг өгч хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Г.2 Өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдсан байна.
- Байгууллагууд шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж мэдээлсэн байна.
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг 95,9 хувьтай мэдээлсэн байна.
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг 99,4 хувьтай мэдээлсэн байна.
- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 6 дугаар зүйлийн 6.5-д заасан мэдээллийг мэдээллэх гэсэн заалт нь Сангийн яамтай холбоотой бөгөөд орон нутагт хамааралгүй болно.
- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлсэн байна.
- Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.9-дэх хэсэгт заасан мэдээллийг журмыг дагуу мэдээллэж байна.
- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг зарим сумын ИТХ хэрэгжүүлээгүй байна.
- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.
- Өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.АЛТАНЗАЯА

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Наранбаатар

- Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтлан мэдээлж байх

АЛБАН ШААРДЛАГА

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд шаардаж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Х.Сугир:

- Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 “энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурал, Төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

Хүрмэн сумын ИТХ-н дарга С.Эрдэнэбаяр:

- Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 “энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурал, Төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

Мандал-Овоо сумын ИТХ-ын дарга О.Отгонбаяр:

- Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 “энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурал, Төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах